



**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/08

Дархан сум

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Монгол Улсын Их Хурлын 2024 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэсний хорооны 2025 оны “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах арга хэмжээний тухай” 01 дүгээр тогтоол, Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталж, хэрэгжилтийг ил тод мэдээлж, тайлагнаж ажиллахыг Санхүү, удирдлагын хэлтсийн менежерийн үүргийг түр хавсран гүйцэтгэгч /Б.Номин-Эрдэнэ/-д даалгасугай

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.ОТГОНБЯАР



"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2025 оны 01 сарын 01 өдрийн Доргоот
тушаалын хабералт

**"ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ" ХХК-ИЙН
"АВЛИГТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт Хүрэх үр дүн	Хэрэгжүүлэх хугацаа
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	<p>1.1 Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг а/байгууллагын албан ёсны цахим хуудас; б/сошиал сувгууд; в/дотоод сүлжээ; г/хэвлэл мэдээллийг хэрэгсэл, д/мэдээлэл сурталчилгаа самбар, лед дэлгэц, е/бусад (салбар байгууллагууд) хэлбэрээр сурталчилж, олон нийтэд хүргэх</p> <p>1.2 Өөрийн байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн соён гэгээрүүлэх нээлттэй хаалганы өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулах</p> <p>1.3 Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах "Шударга ёс, хөгжил дэвшилд 110" мэдээллийн самбар ажиллуулах;</p> <p>1.4. Өөрийн байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал, зэрэгт авлигын хор хөнөөлийг иргэдэд ойлгуулах, шүгэл үлээхийг сурталчлан таниулсан, түүнд уриалсан мэдээлэл болон авлигын мэдээлэл 110 дугаарыг оруулан сурталчлах</p> <p>1.5. Өөрсдийн байгууллагын үйл ажиллагаанд авлигад өртөж болзошгүй чиглэлийг сонгон авлигын эрсдэлээс ангид байхад чиглэсэн, ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 2-оос доошгүй видео контент бүтээж, олон нийтэд хүргэсэн байх.</p>	<p>АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг компанийн тse.mn цахим хуудас, ажилтнуудын FB хуудас, компанийн мэдээллийн самбарт байршуулах</p> <p>АТГ-аас санаачилсан аян, арга хэмжээг компанийн онцлогт тохируулан зохион байгуулах, дэмжиж ажиллах</p> <p>Мэдээллийн самбарыг ажиллуулан, мэдээллийг тогтмол шинэчлэх, АТГ-аас ирүүлсэн мэдээллийг байршуулсан байх</p> <p>Мэдээллийг Авлигатай тэмцэх газраас буюу баталгаат эх сурвалжаас авсан байх;</p> <p>Байгууллагын эрх хэмжээний хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэсэн хэвлэмэл материалд оруулсан байх;</p> <p>Үр дүнг нэгтгэн тайлагнасан байх.</p> <p>Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байх;</p> <p>Авлигын мэдээлэл 110 дугаарын утсыг сурталчилсан байх;</p> <p>Олон нийтэд түгээсэн байх.</p>	Жилдээ Жилдээ Жилдээ Жилдээ Жилдээ
2	Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийг	<p>2.1. Засгийн газрын 2021 оны 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх</p>	<p>Журамд заасны дагуу өөрийн байгууллагын үйл ажиллагааны 1-ээс доошгүй чиглэлд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэхээр сонгосон байх;</p>	Жилдээ

<p>бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх</p>	<p>Сонгосон чиглэлд олон нийтийг хяналтыг хэрэгжүүлэх сонгон шалгаруулалт зарласан байх; Олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэн тайлагнах; Үр дүнд суурилсан арга хэмжээг зохион байгуулсан байх.</p>	<p>Салбарт бүрт үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын нэгдсэн судалгааг гаргасан байх; Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ авсан байх; Үр дүнг тооцож, тайлагнасан байх.</p>	<p>Жилдээ</p>
<p>2.2. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх</p>	<p>2.3. Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангах</p>	<p>2024 онд төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд тогтмол ойлгомжтой байдлаар тогтмол мэдээлэх; Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбоотой иргэд, олон нийтийн саналыг авч, холбогдох арга хэмжээг авах; Иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлэх.</p>	<p>Жилдээ</p>
<p>2.4. Байгууллагуудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой ирүүлсэн гомдол, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлж хэвших</p>	<p>Байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний хүнд суртал чирэгдэлтэй холбоотой гомдол, мэдээллийн судалгааг тогтмол гаргаж, тайлагнах; Хуулийн хүрээнд шуурхай, бодитой шийдвэрлэж хэвших; Иргэд, олон нийтээс Байгууллагын үйл ажиллагаа, хүнд суртал чирэгдэл, холбоотой гомдол мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх.</p>	<p>Жилдээ</p>	<p>Жилдээ</p>

	<p>Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах</p>	<p>3.1. Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр тухайн байгууллагаас цахимаар иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах</p>	<p>Нэвтрүүлсэн цахим үйлчилгээний чанар хүртээмжийн талаар иргэд, олон нийтээс судалгаа, санал асуулга авах; Дүн шинжилгээ хийж, үр дүнд суурилсан арга хэмжээг хэрэгжүүлэх; Хэрэгжилтийг тайлагнах.</p>	<p>Жилдээ</p>
		<p>3.2. Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх;</p>	<p>Албан хаагчидтай холбогдуулан ирүүлсэн авлига, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээллийг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж хэвших; Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээг байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан эрсдэлийг тодорхойлсон байх; Эрсдэлийг арилгах арга хэмжээнд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулсан байх;</p>	<p>Жилдээ</p>
		<p>3.3. Тухайн байгууллага өөрийн үйл ажиллагааны онцлогт тохируулан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр шинээр санал, санаачилга гарган тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэх. Үүнд: * "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн үйл ажиллагааг иргэдэд ил тод нээлттэй хүргэх зорилгоор "Утгах үйлчилгээ"-г ажиллуулж, хэвшүүлэх. * "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн үйл ажиллагааг хэрэглэгчийн хүлээлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх замаар сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхээр ISO-9001 Чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж эхэлнэ. * "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-д шинээр томилогдсон албан хаагчдад зориулж цахим гарын авлага боловсруулж, түгээх.</p>	<p>Төлөвлөгөөний 1.1-3.2 дахь хэсэгт заасан арга хэмжээтэй агуулгаараа давхцахгүй байх; Байгууллагын үйл ажиллагаа, үзүүлж буй төрийн үйлчилгээний онцлогт тохируулан зохион байгуулсан арга хэмжээний үр дүнг олон нийтэд мэдээлсэн байх; Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж, албан бичгийн хэрэгжилтийг хангасан байх; Үйлчилгээ авдаг, хамтарч ажилладаг, зорилтот бүлэгт урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн өөрчлөлт, хүрсэн үр дүнгийн талаар мэдээлэл хүргэсэн байх.</p>	<p>Жилдээ</p>
		<p>Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин хөлс, урамшуулал, тэтгэмж дэмжлэгийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд ил тод мэдээлэх.</p>	<p>Компанийн эрх бүхий албан тушаалтны цалин хөлс, урамшуулал, тэтгэмж дэмжлэгийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтэд цаг тухай бүр ил тод мэдээлэх.</p>	<p>Тухай бүр</p>

		Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг үйл ажиллагааны үндсэн зорилгод нийцээгүй улс төрийн шинжтэй шийдвэр, нийгмийн халамж, тусламж дэмжлэг, хөнгөлөлт, урамшуулал зэрэг ажиллагааны санхүүжилтэд зарцуулахыг таслан зогсоох шийдвэрийн хэрэгжилтийг хангах.	Төрийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгийг үйл ажиллагааны үндсэн зорилгод нийцээгүй улс төрийн шинжтэй шийдвэр, нийгмийн халамж, тусламж дэмжлэг, хөнгөлөлт, урамшуулал зэрэг үйл ажиллагааны санхүүжилтэд зарцуулахгүй байх.	Тухай бүр
		Төрийн өмчит хуулийн этгээдийн баталгаажсан санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайланг олон нийтэд ил тод мэдээлж байх.	Компанийн баталгаажсан санхүүгийн, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тайланг олон нийтэд ил тод мэдээлж байх.	Тухай бүр
		Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээс хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан аливаа гэрээ, хэлцэл, түүний гүйцэтгэл олон нийтэд нээлттэй, ил тод байлгах.	"Хөдөө аж ахуйн бирж" ХХК-аас хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд байгуулсан аливаа гэрээ, хэлцэл, түүний гүйцэтгэл олон нийтэд нээлттэй, ил тод байлгах, шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд оруулах.	Тухай бүр
		Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ын дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийн төлөөлөл болон хараат бус гишүүн, хуулийн этгээдийн сул орон тоон дээр сонгон шалгаруулалт нээлттэй явуулах.	Засгийн газрын 2023 оны 84, 85, 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн өмчийн хуулийн этгээдийн ажлын байрны сул орон тоонд нээлттэй сонгон шалгаруулалт явуулах нийтлэг журам"-ын дагуу төрийн өмчит хуулийн этгээдийн Төлөөлөн удирдах зөвлөлийн төрийн төлөөлөл болон хараат бус гишүүн, хуулийн этгээдийн сул орон тоон дээр сонгон шалгаруулалт нээлттэй явуулах, журмыг мөрдөж ажиллах.	Тухай бүр